

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

Хяналт шалгалтын нэр: 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалт

Хамрагдсан байгууллага: Хот байгуулалт, хотын стандартын газар

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ТАНИЛЦУУЛГА	3
<i>Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар.....</i>	<i>5</i>
<i>Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар.....</i>	<i>6</i>
<i>Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар</i>	<i>16</i>
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ	17
ДҮГНЭЛТ.....	20
ЗӨВЛӨМЖ.....	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НДАГ	Нийслэлийн Дотоод аудитын газар
НХБХСГ	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
НДС	Нийгмийн даатгалын сан

ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар нь нийслэлийн Засаг даргын (НЗД)-ын 1995 оны 12 сарын 15-ны өдрийн А/276 дугаар захирамжаар анх байгуулагдсан байна. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 1996 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн Б/2 дугаар тушаалаар Барилга, хот байгуулалтын албаны мэргэжилтнүүдийг газрын харилцаа, хот байгуулалтын газрын мэдэлд шилжүүлсэн байна.

НЗД-ын 2000 оны 160 дугаар захирамжаар Хот байгуулалт, газрын харилцааны газар нэртэй үйл ажиллагаагаа явуулсан, МУЗГ-ын 2003 оны 58 дугаар тогтоолоор нийслэлийн Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Газрын алба гэсэн 2 тусдаа байгууллага болон зохион байгуулагдсан байна.

Нийслэлийн Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын үйл ажиллагааны чиг үүрэг нь бүтцийн өөрчлөлтөөр 2004 онд НЗДТГ-ын Стратеги бодлого, төлөвлөлтийн хэлтэст шилжсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын (МУЗГ)-ын 2006 оны тоот 196 тоот тогтоол, НЗД-ын 2006 оны А/486 дугаар захирамжаар газар нэртэйгээр хэрэгжүүлэгч агентлаг болон шинээр байгуулагдсан байна.

НЗД-ын 2013 оны А/25 дугаар дугаар захирамжаар нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, зэрэг нэрээр тус тус шинэчлэн зохион байгуулагдсан. МУЗГ-ын 2019 оны 100 дугаар тогтоолоор нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулсан байна.

НЗД-ын 2022 оны А/115 дугаар захирамжаар Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дүрмийг баталж, /хуучин нэрээр/, НЗД-ын 2024 оны А/478 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хотын стандартын газрын дүрмийг тус тус баталсан байна.

Хот байгуулалт, хөгжлийн газар нь Эрхэм зорилгоо “нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт, дунд богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн нийслэлийн нийгэм, эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан иргэдийн оролцоотой төлөвлөх, хот байгуулалтын үйл ажиллагааг орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан хурдан шуурхай, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар нь регистрийн 2117401 дугаартай, ХУД-ийн 23 дугаар хороо, Хангарьд 2 дугаар байрны 10 дугаар давхарт үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн сан банк дахь үндсэн данс 100200051054, хөрөнгө оруулалтын 100200051307, нэмэлт санхүүжилтийн 100200051450, барьцаа хөрөнгийн 100200051340, ахмадын сангийн 100200051504 дугаар дансуудаар бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Шалгалтад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 21 хүртэл Б/66 дугаар захирамжаар томилогдсон Ц.Тулга, 2023 оны 11 дүгээр сарын 21-ээс 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл Б/120 дугаар захирамжаар Д.Хан-Уул, 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хооронд Б/13 дугаар захирамжаар Г.Батзориг, 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хооронд Б/110 дугаар захирамжаар Ч.Төгсдэлгэр, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Б/179 дугаар захирамжаар Г.Баярсайхан нар, хоёрдугаар гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Б/41 дүгээр тушаалаар Б.Эрдэнэмөнх, 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хооронд Б/35 дугаар тушаалаар Д.Уянга, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс

Б/143 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогч Б.Болормаа нар тус тус зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

Өмнөх шалгалтын талаар:

Тус газрын 2023 оны санхүүгийн тайланд нийслэл дэх Төрийн аудитын газар аудитыг гүйцэтгэн “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар 44,191.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- Албан хаагчдад 40,320.0 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тодорхой үзүүлэлтгүй олгосон
- Байгууллагын албан хаагчийн гэр бүлд 3,871.6 мянган төгрөгийн бэлэг өгсөн зөрчил илрүүлжээ.

Тайлант 2024 оны санхүүгийн тайланд нийслэл дэх Төрийн аудитын газар аудитыг гүйцэтгэн “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт хүргүүлсэн байна. Аудитаар 29,607.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Үүнд:

- Барьцаа дансанд ахмадын сангийн 20,000.0 мянган төгрөгийн орлого бүртгэж тайлагнасан
- Тайлант онд 8,749.0 мянган төгрөгийн ебаримт дутуу олгож, санхүү татварын тайланг зөрүүтэй бүртгэж тайлагнасан
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тооцож 858.1 мянган төгрөгөөр хөрөнгийн үлдэгдэл өртгийг бууруулж тайлагнасан байна.

Нийслэлийн Дотоод аудитын албанаас Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын /хуучин нэрээр/ 2021 он, 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хэрэгжүүлж цаашид давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгч ажилласан байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

Санхүүгийн хяналт шалгалт хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1 “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг ажиллуулж, дотоод аудитор ажиллуулна”, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Нийслэлийн Дотоод аудитын албаны “Аудит, хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө”, Нийслэлийн Засаг дарга (НЗД) бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн баталсан 2025 оны 09 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын 2023-2024 оны үйл ажиллагаанд Аудит, хяналт шалгалтын хэлтсийн ахлах дотоод аудитор СХШУАБ Д.Лувсанчимэд, дотоод аудитор СХШУБ Ц.Дуламдорж, дотоод аудитор Б.Отгонтуяа нар 2025 оны 06 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн ажлын 10 хоногийн хугацаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтын зорилго

Тус байгууллагын үйл ажиллагаа нь төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай нийцэж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

Хяналт шалгалтын цар хүрээ

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал, тооллого, тооцоо бодолт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Дээд шатны төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Тусгай сангуудын төлөвлөлт, зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Хандив тусламжийн хөрөнгө түүний зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ноогдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын авлага, өр төлбөрийн үүсэн байдал, барагдуулалт, тооцоо нийлсэн актаар баталгаажсан эсэх;
- Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, түүнтэй холбоотой үйл ажиллагааны гүйцэтгэл;
- Өмнө хийгдсэн шалгалт, акт, албан шаардлага, зөвлөмжийн барагдуулалт зэргийг хамруулан шалгалаа.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02-00/32 дугаартай хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд тус газарт хяналт шалгалт хийгдэж байна.

Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/478 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, хотын стандартын газрын дүрмийг баталсан байна.

Дүрэмдээ “Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтууд болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас хот байгуулалт, төлөвлөлт, барилгын талаар бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн” гэж заасан байна.

Бүтэц орон тоо

Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 2022 оны А/1059 дугаар захирамжийн хавсралтаар тус байгууллагын бүтэц орон тооны хязгаарыг 1 ажлын алба, 10 хэлтэс, 98 хүртэл албан хаагчтайгаар, Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог баталсан байна.

ЗГ-ын 2024 оны “НЗДТГ, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 81 дүгээр тогтоол, НЗД-ын 2024 оны А/443 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 1 ажлын алба, 10 хэлтэс, 128 албан хаагч байхаар шинэчлэн баталсан. Дээрх захирамжийн дагуу Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2024 А/46, А/69 дүгээр тушаалаар бүтэц орон тоог баталсан байна.

Үүнээс гүйцэтгэлээр 2023 онд 88, 2024 онд 104 орон тоотой тус тус ажилласан байна.

Хүснэгт 1. Батлагдсан бүтэц орон тоо

№	Хэлтэс нэгжийн нэр	Батлагдсан орон тоо 2023 он	Гүйцэтгэл 2023 он	Батлагдсан орон тоо 2024 он	Гүйцэтгэл 2024 он
	2023 он				
	Газрын дарга	1	1	1	1
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	15	14	18	17
2	Ерөнхий архитекторын ажлын алба	10	10	13	10
3	Барилга, хот байгуулалтын хэлтэс	10	10	13	11
4	Хот төлөвлөлтийн хэлтэс	10	10	16	13
5	Хот байгуулалтын мэдээллийн хэлтэс	10	7		
6	Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтэс	10	9		
7	Барилга байгууламжийн чанарын хэлтэс	8	4		
8	Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	9	9		
9	Хот байгуулалтын инженерийн бэлтгэл, хяналтын хэлтэс	8	7		
10	Дотоод хяналт, хуулийн хэлтэс	7	7		
11	Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс			14	11
12	Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс			11	9
13	Барилга байгууламжийн чанар, стандартын хэлтэс			6	6
14	Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс			7	7
15	Хотын стандарт, хөгжлийн хэлтэс			15	9
16	Хот байгуулалтын хяналтын хэлтэс			8	5
17	Хуулийн хэлтэс			6	5
	Нийт	98	88	128	104

Тайлант 2023 онд төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 38 ажлын байранд давхардсан тоогоор 47 сул орон тоог нөхөхөөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 5 удаагийн нээлттэй сонгон шалгаруулалтаар 19 ажлын байрыг, 2024 онд давхардсан тоогоор 22 ажлын байрны 31 сул орон тоог зарлаж, сонгон шалгаруулалтаар 12 ажлын байрыг тус тус нөхсөн байна.

Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Санхүүгийн тайлангийн талаар:

Тайлант 2023 оны санхүүгийн байдлын тайланд 1,601,968.3 мянган төгрөгийн эргэлтийн, 5,033,179.2 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 6,635,147.5 мянган төгрөгийн хөрөнгийг, 2024 оны санхүүгийн байдлын тайланд 9,645,456.7 мянган төгрөгийн эргэлтийн, 5,941,182.6 мянган төгрөгийн эргэлтийн бус, нийт 15,586,639.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус тайлагнасан байна.

Хүснэгт 2.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31	2024.12.31
Мөнгөн хөрөнгө	249,204.1	241,037.5	352,489.0
Авлага	2,272.5	83.3	100.0
Урьдчилгаа	4,166,837.2	1,342,996.2	9,150,811.9
Бараа материал	32,613.6	17,851.30	142,055.8
Эргэлтийн хөрөнгийн дүн	4,450,927.5	1,601,968.3	9,645,456.7
Биет хөрөнгө	190,216.1	164,306.6	803,341.3
Биет бус хөрөнгө	608,510.1	4,868,872.6	5,137,841.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	798,726.2	5,033,179.2	5,941,182.6
Нийт хөрөнгө	5,249,653.6	6,635,147.5	15,586,639.3
Өглөг	250,050.7	243,579.3	332,489.0
Засгийн газрын оруулсан капитал	1,141,468.6	1,141,468.6	1,141,468.6
Хуримтлагдсан үр дүн	3,858,134.3	5,250,099.6	14,112,681.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, өмчийн дүн	5,249,653.6	6,635,147.5	15,586,639.2

Мөнгөн хөрөнгийн талаар:

Тайланд 2023 онд Мөнгөн хөрөнгө дансанд 241,037.5 мянган төгрөгийн, 2024 онд 352,489.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 352,489.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 111,451.5 мянган төгрөгөөр өссөн нь 175,759.9 мянган төгрөгийн барьцааны орлого орж, 84,308.5 мянган төгрөгийн барьцаа чөлөөлж, ахмадын сангийн орлого 20,000.0 мянган төгрөгийн орлогыг цалингийн сангаас төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Авлага дансны талаар:

Тайлант 2023 онд цахилгаан холбоо ХХК-аас авах 83.3 мянган төгрөгийн, 2024 онд утасны дугаарын барьцаа 100.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

Авлага дансны дансны үлдэгдэл 100.0 мянган төгрөг болж өссөн нь өмнөх оны татварын авлагыг бүрэн барагдуулж, тайланд онд утасны дугаарын барьцаа байршуулснаас шалтгаалсан байна.

Урьдчилж гарсан зардлын талаар:

Тус дансанд хөрөнгө оруулалтын ажлын явцын санхүүжилтийг бүртгэдэг байна.

Тайлант 2023 онд 8 ажлын нийт 1,342,996.2 мянган төгрөгийн, 2024 онд 6 ажлын нийт 9,150,448.6 мянган төгрөгийн явцын санхүүжилт, бараа материал бэлтгэх урьдчилгаа дансанд 363.3 мянган төгрөгийн шатахууны урьдчилгаа нийт 9,150,811.9 мянган төгрөгийн зардал бүртгэжээ.

Хүснэгт 3.

Урьдчилж төлсөн зардлын задаргаа

(мянган төгрөгөөр)

№	Ажлын нэр	2023 он	2024 он
1	"Бичил" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БГД 9, 10-р хороо/	91,752.0	-
2	"Ургах наран" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД11-р хороо/	92,624.0	-

3	"Хайлааст" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /ЧД 12-р хороо/	94,560.0	-
4	"Дарь-Эх" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 27-р хороо/	92,008.4	92,008.4
5	"Монель" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 4,5-р хороо/	92,008.4	92,008.4
6	"Тахилт" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /СХД 33-р хороо/	92,008.4	92,008.4
7	Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ	618,035.0	-
8	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн ТЭЗҮ, ХЕТ	170,000.0	-
9	"Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах	-	1,954,590.0
10	"УБХотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ	-	3,099,750.0
11	Зайсан орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гэрээ	-	159,000.0
12	"Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох"	-	1,679,923.4
13	"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт боловсруулах ажлын гэрээ	-	658,560.0
14	Ашиглалтын шаардлага хангахгүй 5 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил /СБД 6-р хороо/	-	1,322,600.0
15	Шахахууны урьдчилгаа	-	363.3
Нийт дүн		1,342,996.2	9,150,811.9

Бараа материалын талаар:

Тайлант 2023 онд төсвийн хөрөнгөөр 36,268.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 55.6 мянган төгрөгийн бараа материал орлогод авч, албаны хэрэгцээнд 38,181.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн газрын даргын 2023 оны А/36, А/46 дугаар тушаалуудаар 12,849.1 мянган төгрөгийн бараа материалыг аклан устгаж, нийт 17,851.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Хүснэгт 4

Бараа материалын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр /Материал/	2023 он				2024 он		
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагд Сан	Эцсийн үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагд сан	Эцсийн үлдэгдэл
1	Тусгай зориулалт	-	-	-	-	88,500.0	-	88,500.0
2	Бичиг хэрэг	5,513.3	32,181.8	34,278.2	3,416.9	42,915.5	35,336.9	10,995.5
3	Аж ахуй	27,100.3	1,996.4	14,802.3	14,294.4	46,826.0	18,561.0	42,559.4
4	Түлш, шатах тослох	-	2,090.0	1,950.1	139.9	513.7	652.8	0.8
Нийт дүн		32,613.6	36,268.2	51,030.6	17,851.2	178,755.2	54,550.7	142,055.7

Тайлант 2024 онд төсвийн хөрөнгөөр 62,511.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, бүтцийн өөрчлөлтэй холбоотой 112,297.9 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 3,918.7 мянган төгрөгийн бараа материал тус тус шилжин ирж, шатахууны урамшууллын 27.1 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэн авч, үндсэн үйл ажиллагааны зардалд 48,751.8 мянган төгрөгийн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 5,798.1 мянган төгрөгийн бараа материалыг байгууллын даргын 2024 оны А/102 дугаар тушаалаар акталж, нийт 142,055.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Тайланд 2023 оны төсвийн хөрөнгөөр 1,912,827.1 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 2,808,540.9 мянган төгрөгийн өнгөрсөн оны урьдчилж гарсан зардлаар бүртгэгдсэн

ажлыг биет бус хөрөнгөөр бүртгэн авч, НӨХГ-ын даргын 2023 оны А/79 дүгээр тушаал, Газрын даргын А/23 дүгээр тушаалаар 172,375.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устган, 487,089.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, нийт 5,033,179.2 мянган төгрөгийн үлдэх өртөг тайлагнасан байна.

Тайланд 2023 оны төсвийн хөрөнгөөр 1,912,827.1 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 2,808,540.9 мянган төгрөгийн өнгөрсөн оны урьдчилж гарсан зардлаар бүртгэгдсэн ажлыг биет бус хөрөнгөөр бүртгэн авч, НӨХГ-ын даргын 2023 оны А/79 дүгээр тушаал, Газрын даргын А/23 дүгээр тушаалаар 172,375.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устган, 487,089.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, нийт 5,033,179.2 мянган төгрөгийн үлдэх өртөг тайлагнасан байна.

Хүснэгт 5

Үндсэн хөрөнгийн тайлан /2023 он/

(мянган төгрөгөөр)

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгд Сэн	Хасагд Сан	Эцсийн үлдэгдэл	Элэгдлийн зардал	Хуримтлагд сан элэгдэл	Үлдэх өртөг
Машин, тоног төхөөрөмж	1,406,832.9	46,488.0	136,004.2	1,317,316.7	63,640.1	1,157,819.8	159,496.9
Тавилга эд хогшил	196,870.0		5,794.4	191,075.6	8,631.8	186,265.9	4,809.7
Программ хангамж	611,683.6		30,577.0	581,106.6		581,106.6	
Тээврийн хэрэгсэл	47,100.0			47,100.0		47,100.0	
Бусад биет бус хөрөнгө	8,363,054.3	4,675,180.1		13,038,234.4	414,817.5	8,169,361.8	4,868,872.6
Нийт дүн	10,625,540.8	4,721,668.1	172,375.6	15,174,833.3	487,089.4	10,141,654.1	5,033,179.2

Тайлант 2024 оны санхүүгийн тайланд 2,546,480.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс 1,656,056.2 мянган төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалт болон байгууллагын төсвөөр бэлтгэж, 715,406.4 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, 61,700.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, бүтцийн өөрчлөлтөөр 111,317.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 1,893,686.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсанаас 193,914.6 мянган төгрөгийн хөрөнгийг актлаж, НЗД-ын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/304 дугаар захирамжаар Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк 47,100.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж бүтцийн өөрчлөлтөөр, Орон сууцны бодлогын газарт зарим чиг үүрэг шилжсэнтэй холбоотойгоор НӨХГ-ын даргын А/730, А/797 дүгээр тушаал, НХБХСГ-ын даргын 2024 оны А/101 дүгээр дүгээр Хот байгуулалт, хотын стандартын газрын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,493,793.4 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ хөрөнгийг НОСБГ-т, 158,878.8 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ хөрөнгийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт тус тус балансаас балансад шилжүүлж, нийт Орон сууцны бодлогын газарт 1,652,672.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлж, 1,565,047.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, 5,941,182.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тус тус тайлагнасан байна. Тухайлбал:

НЗД-ын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/423 дугаар захирамжаар бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дараах хөрөнгүүд шилжиж ирснийг бүртгэсэн байна. Үүнд: Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай хөгжлийн газрыг татан буулгаж, нэгтгэгдсэнтэй холбоотойгоор НӨХГ-ын даргын 2024 оны А/210 тушаалаар 38,595.3 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж 28,844.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 67,439.3 мянган төгрөгийн хөрөнгө;

НЗД-ын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Хяналт шалгалтын газрын зарим чиг үүрэг шилжин ирсэнтэй холбоотойгоор НӨХГ-ын даргын 2024 оны А/142 дүгээр тушаалаар 20,193.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 3,694.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 23,888.2 мянган төгрөгийн хөрөнгө;

Нийслэлийн Орон сууцны корпорац ХК-аас шилжиж ирсэн НӨХГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/138 дугаар тушаалаар 19,990.0 мянган төгрөгийн тоног

төхөөрөмж, нийт 111,317.5 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд тусгажээ.

НЗД-ын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/439 дугаар захирамжаар 61,700.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл Төр захиргааны авто баазаас балансаас балансад, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/72 захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 715,406.4 мянган төгрөгийн хөрөнгө НЗД-ын 2021 оны Эрх шилжүүлэх тухай А/524, 2022 оны Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай А/304, А/779 захирамж, 2024 оны эрх шилжүүлэх тухай А/228 захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвөөр 2021-2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, 2024 оны урсгал байгууллагын зардлаар хийгдсэн ажлын нийт 1,658,056.2 мянган төгрөгийн хөрөнгө, нийт 2,439,081.3 мянган төгрөгийн хөрөнгө тус тус орлогод авч, нийт 2,546,480.1 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгажээ.

Хүснэгт 6

Үндсэн хөрөнгийн тайлан /2024 он/

(мянган төгрөгөөр)

Дансны нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгд Сэн	Хасагд сан	Эцсийн үлдэгдэл	Элэгдлийн зардал	Хуримтлагд сан элэгдэл	Үлдэх өртөг
Машин, тоног төхөөрөмж	1,317,316.7	808,372.8	179,985.5	1,945,704	117,041.8	1,168,305.3	660,356.9
Тавилга эд хогшил	191,075.6	32,538.8	15,321.1	208,293.3	11,405.9	182,350.7	25,942.6
Программ хангамж	581,106.6	5,876.5	498.0	586,485.1	162.3	580,770.9	5,714.2
Тээврийн хэрэгсэл	47,100.0	61,700.0	47,100.0	61,700.0	-	61,700.0	-
Бусад биет бус хөрөнгө	13,038,234.4	1,637,992.0	1,650,782.3	13,025,444.1	1,374,737.5	7,893,317.0	3,757,389.0
Нийт дүн	15,174,833.3	2,546,480.1	1,893,686.9	15,827,626.5	1,503,347.5	9,886,443.9	4,449,403.3

Өр төлбөрийн талаар:

Тайлант 2023 онд 9 ажлын 241,037.5 мянган төгрөгийн, 2024 онд 11 ажлын 332,489.0 мянган төгрөгийн барьцаа тайлагнасан байна.

Хүснэгт 7

Барьцаа хөрөнгийн данс

(мянган төгрөгөөр)

№	Төсөл арга хэмжээний нэр	2023 он	2024 он
1	Багахангай дүүргийн Үйлдвэрлэл технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	8,750.0	-
2	УБ хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	71,910.0	71,910.0
3	"Шинэ төв" дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /СХД 32-р хороо/ боловсруулах зөвлөх үйлчилгээ	22,284.0	-
4	"Сонсголон" дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /СХД 3-р хороо/ боловсруулах зөвлөх үйлчилгээ	14,913.0	-
5	"Нисэх" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /ХУД 9-р хороо/ боловсруулах зөвлөх үйлчилгээ	11,286.0	-
6	Амгалан дэд төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын тэсэл /УБХ, БЗД 8,9,10,17,23 дугаар хорооны 127 га/ зураг төсөл боловсруулах	17,451.0	-
7	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд олон нийтэд нээлттэй болгох	9,624.5	-
8	Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн "Улсын хаягийн нэгдсэн систем"-д бүрэн холбох ажил /Улаанбаатар хот/	8,699.1	8,699.1
9	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил	76,119.9	76,119.9
10	Газар хөдлөлийн чичирхийлэлийг хэмжигч багаж	-	8,756.5
11	"Бичил" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БГД 9, 10-р хороо	-	11,469.0
12	"Ургах наран" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД11-р хороо/	-	11,578.0
13	"Хайлааст" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /ЧД 12-р хороо/	-	11,820.0

14	Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ	-	36,355.0
15	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн ТЭЗҮ, ХЕТ	-	10,000.0
16	Ашиглалтын шаардлага хангахгүй 5 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил / СБД 6-р хороо/	-	66,131.5
17	"Ebarilga" Нийслэлийн хот байгуулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх гэрээ	-	19,650.0
Нийт дүн		241,037.5	332,489.0

Өөрийн орлогын талаар:

Барилгын чанарын дүгнэлт гаргуулахаар 41 харилцагч хандсанаас 2 харилцагчийн дүгнэлт гарсан байтал дүгнэлтээ аваагүй шалтгаанаар 937.0 мянган төгрөгийн орлого тушаагаагүй, мөн 3 харилцагч он дамжин 5,605.2 мянган төгрөгийн орлогыг он дамжин төлсөн байна.

Хүснэгт 8

Барилгын чанарын дүгнэлтийн орлого

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт		2023 он		2024 он		Нийт дүн	
		Харилцагч	Орлого	Харилцагч	Орлого	Харилцагч	Орлого
Орсон орлого		15	28,921.5	21	19,214.7	36	48,136.2
Үүнээс:	Он дамжсан орлого	1	756.3	2	4,848.9	3	5,605.2
	Дүгнэлтээ аваагүй	2	937.0			2	937.0

Тайлант онуудад 3075 иргэн ААН-ийн 137,054.1 мянган төгрөгийн хаяг, дугаарын тодорхойлолтын орлого төвлөрсөн бөгөөд орлого тушаасан боловч хаяг, дугаарын тодорхойлолт аваагүй 301 иргэн ААН-ийн 7,554.6 мянга, хаяг, дугаарын тодорхойлолт авсан боловч орлого нь тайлант онд төвлөрөөгүй он дамжсан 34 иргэн ААН-ийн 2,265.6 мянган төгрөгийн орлогыг аккурэль сууриар бүртгээгүй, мөн харилцагч нь тодорхойгүй 93 иргэн, ААН-ийн 6,720.7 мянган төгрөгийн орлого тайлант оны орлогоор бүртгэсэн байна. Үүнд:

Хүснэгт 9 Барилгын мэдээллийн сангаас хаяг, дугаарын тодорхойлолт олгох орлого

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт		2023 он		2024 он		Нийт дүн	
		Харилцагч	Орлого	Харилцагч	Орлого	Харилцагч	Орлого
Орсон орлого		1,445	66,831.1	1,630	70,223.0	3,075	137,054.1
Үүнээс	Он дамжсан орлого	20	1,883.3	14	382.4	34	2,265.6
	Хаяг, дугаарын тодорхойлолт аваагүй	131	3,221.3	170	4,333.3	301	7,554.6
	Тодорхойгүй орлого	41	2,622.6	52	4,098.1	93	6,720.7

Тайлант онуудад 353 иргэн ААН-ийн 35,715.4 мянган төгрөгийн зургийн орлого төвлөрсөн бөгөөд орлого тушаасан боловч ажлаа хүлээж аваагүй 102 иргэн ААН-ийн 12,961.4 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Хүснэгт 10 Шугам сүлжээний дэвсгэр зураг, сэдэвчилсэн болон байр зүйн зургийн орлого

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт		2023 он		2024 он		Нийт дүн	
		Харилцагч	Орлого	Харилцагч	Орлого	Харилцагч	Орлого
Орсон орлого		181	21,432.5	172	14,282.9	353	35,715.4
Үүнээс: Зураг аваагүй		47	9,695.6	55	3,265.8	102	12,961.4

Төсвийн санхүүжилт, гүйцэтгэлийн талаар:

Хот байгуулалт, хотын стандартын газар нь тайлант 2023 оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 2,557,730.3 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,220,518.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 141,607.2 мянган төгрөгийг бүрдүүлж үйл ажиллагаандаа 2,340,518.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 21,607.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Санхүүжилтийн эрхийг орон нутгийн төсвөөс 217,212.1 мянган төгрөгийн дутуу буюу 2,220,518.2 мянган төгрөгөөр нээсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,340,518.2 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 217,183.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж 28.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 11

Төсвийн гүйцэтгэлийн талаар

(мянган төгрөгөөр)

Зардлын үзүүлэлт	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,126,346.8	1,971,413.4	154,933.3	3,509,477.6	2,902,362.6	607,114.9
Нийгмийн даатгалын шимтгэл	265,793.5	252,294.57	13,498.9	444,892.4	370,058.9	74,833.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,313.2	11,288.2	4,025.0	17,479.2	8,592.02	8,887.2
Байрны түрээс	15,313.2	11,288.2	4,025.0	17,479.2	8,592.02	8,887.2
Хангамж, бараа материалын зардал	46,875.8	43,488.8	3,441.9	58,673.2	50,965.	7,707.2
Бичиг хэрэг	13,312.0	13,311.9	0.02	21,645.0	21,399.5	245.5
Тээвэр шатахуун	14,738.8	9,654.5	5,084.2	3,032.9	1,568.2	1,464.7
Шуудан холбоо, интернэт төлбөр	18,825.0	20,467.3	-1,642.3	31,348.0	25,357.7	5,990.3
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс			0.0	2,647.3	2,640.53	6.77
Нормативд зардалд	6,000.0	0	6,000.0	1,396.0	981.75	414.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000.0	0	6,000.0	1,396.0	981.7	414.2
Эд хогшил, урсгал засварын зардал	11,785.0	11,690.1	94.8	48,810.0	44,844.3	3,965.7
Багаж, техник хэрэгсэл				22,650.0	22,484.3	165.7
Урсгал зардал	11,785.0	11,690.18	94.8	26,160.0	22,380.0	3,800.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	54,516.0	20,925.1	33,590.8	262,143.0	252,897.93	9,245.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	18,000.0	3,236.0	14,764.0	18,000.0	17,000.0	1,000.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,390.0		9,390.0	4,890.0	4,125.0	765.0
Даатгалын үйлчилгээ	1,508.0		1,508.0	1,508.0		1,508.0
Тээврийн хэрэгслийн татвар	155.0	97.5	57.5	155.0		155.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	33.0		33.0	60.0		60.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,400.0	4,339.1	60.83	214,970.2	211,997.4	2,972.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,030.0	13,252.5	7,777.5	22,559.8	19,775.5	2,784.2
Бараа үйлчилгээний бусад зардал	11,100.0	9,501.2	1,598.8	19,530.0	17,621.6	1,908.3
Бараа үйлчилгээний бусад зардал	10,600.0	9,001.2	1,598.8	14,600.0	12,691.6	1,908.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500.0	500.0	0.0	4,930.0	4,930.0	0.0
Урсгал шилжүүлэг	20,000.0	19,971.6	28.4	123,793.4	78,776.3	45,017.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал			0.0	29,667.0	29,667.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			0.0	46,126.4	23,013.3	23,113.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000.0	19,971.6	28.4	48,000.0	26,098.0	21,904.0
Нийт зардлын дүн	2,557,730.3	2,340,518.2	217,212.1	4,486,194.8	3,727,101.53	759,093.3

Тайлант 2024 оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,366,194.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 120,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос нийт 4,486,194.8 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 4,486,194.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны зардалд 3,727,101.5 мянган төгрөгийг зарцуулж, 759,093.3 мянган төгрөг байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар

Тайлант 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор орон сууц болон олон нийтийн зориулалттай барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажилд НЗД-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/11 дугаар захирамжаар 149,800.0 мянган төгрөг батлагдан, сонгон шалгаруулалтаар Эгэ ХХК шалгарч, тус ажлыг гүйцэтгэсэн байна.

Тайлант 2024 онд нэмэлт санхүүжилтийн дансанд НЗДТГ-аас 12,460.0 мянган төгрөг, НИТХ-аас 324,930.0 мянган төгрөг төвлөрч, гүйцэтгэлээр 1 ажилд 8,756.3 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө суутган, нийт 328,633.5 мянган төгрөгийн хөрөнгийг захирамжийн дагуу зарцуулжээ.

Хүснэгт 12 Нэмэлт санхүүжилтийн 2024 оны зарцуулалтын талаар

(мянган төгрөгөөр)

д/д	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр	Батлагдсан төсвийн захирамжийн дугаар	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Нийт гүйцэтгэл	Барьцаа
1	Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай амьдралын орчин, бүтээн байгуулалтыг бий болгоход чиглэсэн хотын стандартын тогтолцоог бий болгон хөгжүүлэх 9 бүлгийн 20 хотын стандартын төсөлд олон нийтээс санал авч хэлэлцүүлэг зохион байгуулах тухай	НЗД 2024.09.16 А/1077	6,000.0	6,000.0	6,000.0	-
2	Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор орон сууц болон олон нийтийн зориулалттай барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах /18 барилга/	НИТХ 2024.03.20 А/28	150,000.0	149,800.0	149,800.0	-
3	Газар хөдлөлийн чичирхийлэл хэмжигч төхөөрөмж худалдан авах /2нүүдлийн станц/	НИТХ 2024.03.20 А/29	180,000.0	175,130.0	166,373.5	8,756.5
4	"Олон төвт хот-иргэдийн оролцоо" сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	НЗД 2024.11.27 А/1388	6,460.0	6,460.0	6,460.0	-
Нийт дүн			342,460.0	337,390.0	328,633.5	8,756.5

Хөрөнгө оруулалтын ажил:

Тайлант 2023 онд он дамжин хэрэгжсэн 12, тайлант оны 1, нийт 13 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 5 төсөл арга хэмжээнд 1,645,734.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 94,443.5 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, 18,361.2 мянган төгрөгийн алданги торгууль суутган авч, 227,805.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 13 Хөрөнгө оруулалтын ажил 2023 он

(мянган төгрөгөөр)

д/д	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр	Захирамжийн дугаар	Гүйцэтгэгч	Гэрээний дүн	Өмнөх онд олгосон санхүүжилт	Барьцаа суутгасан	2023 онд шилжүүлсэн	Үлдэгдэл санхүүжилт
1	"Бичил" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БГД 9, 10-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Арткон ХХК	114,690.0	91,752.0	-	-	22,938.0
2	"Ургах наран" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД11-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Арткон ХХК	115,780.0	92,624.0	-	-	23,156.0
3	"Хайлааст" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /ЧД 12-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Арткон ХХК	118,200.0	94,560.0	-	-	23,640.0

4	"Дарь-Эх" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 27-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Зураг төсөл консалтинг ХХК	115,010.5	92,008.4	-	-	23,002.1
5	"Монель" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 4,5-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Зураг төсөл консалтинг ХХК	115,010.5	92,008.4	-	-	23,002.1
6	"Тахилт" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /СХД 33-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Зураг төсөл консалтинг ХХК	115,010.5	92,008.4	-	-	23,002.1
7	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд олон нийтэд нээлттэй болгох	НЗД-ын 2022.02.14 А/170	Смарт дата ХХК	192,490.3	80,000.0	9,624.5	102,865.8	-
8	Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн "Улсын хаягийн нэгдсэн систем"-д бүрэн холбох ажил /Улаанбаатар хот/	НЗД-ын 2022.02.14 А/170	Ай Си Ти групп ХХК	173,981.8	69,592.7	26,097.3	78,291.8	0.0
9	Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ	НЗД-ын 2022.09.27 А/1234	Хот төлөвлөлт судалгааны институт	727,100.0	618,035.0	-	-	109,065.0
10	Өрөгт бүтээцтэй 40.0м2, 60.0м2, 80.0м2, 100.0м2, 120.0м2 талбай бүхий гамшигт тэсвэртэй амины сууцны нэг маягийн загвар зураг төсөв	НЗД-ын 2022.04.25 А/554	Эм Эм инженеринг ХХК	48,152.6	38,522.1	481.5	9,149.0	-
11	Төмөрбетон бүтээцтэй 40.0м2, 60.0м2, 80.0м2, 100.0м2, 120.0м2 талбай бүхий гамшигт тэсвэртэй амины сууцны нэг маягийн загвар зураг төсөв	НЗД-ын 2022.04.25 А/554	Эм Эм инженеринг ХХК	48,152.6	38,522.1	481.5	9,149.0	-
12	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн ТЗҮ, ХЕТ	НЗД-ын 2022.06.06 А/779	Хот төлөвлөлт судалгааны институт	200,000.0	170,000.0	-	-	30,000.0
13	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил	НЗД-ын 2023.12.08 А/1380	Монтед констракшн ХХК	1,522,398.6	-	76,119.9	1,446,278.7	-
Нийт дүн			-	3,605,977.5	1,569,633.1	112,804.8	1,645,734.3	277,805.3

Тайлант 2024 онд он дамжин хэрэгжсэн 11, тайлант оны 3 нийт 14 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 11 төсөл арга хэмжээнд 8,935,790.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 147,353.5 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө суутган авч, 9,013,455.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 14

Хөрөнгө оруулалтын ажил 2024 он

(мянган төгрөгөөр)

д/д	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр	Захирамжийн дугаар	Гүйцэт гэгч	Гэрээний дүн	Өмнөх онд олгосон санхүүжилт	Барьцаа суутгасан	2023 онд шилжүүлсэн	Үлдэгдэл санхүүжилт
1	"Бичил" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БГД 9, 10-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Арткон ХХК	114,690.0	91,752.0	11,469.0	11,431.0	38.0
2	"Ургах наран" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД11-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Арткон ХХК	115,780.0	92,624.0	11,578.0	11,578.0	-
3	"Хайлааст" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /ЧД 12-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Арткон ХХК	118,200.0	94,560.0	11,820.0	11,780.0	40.0
4	"Дарь-Эх" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 27-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Зураг төсөл консалтинг ХХК	115,010.5	92,008.4	-	-	23,002.1
5	"Монель" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /БЗД 4,5-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Зураг төсөл консалтинг ХХК	115,010.5	92,008.4	-	-	23,002.1
6	"Тахилт" олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл /СХД 33-р хороо/	НЗД-ын 2021.06.30 А/524	Зураг төсөл консалтинг ХХК	115,010.5	92,008.4	-	-	23,002.1
7	Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу	НЗД-ын 2022.09.27 А/1234	Хот төлөвлөлт	727,100.0	618,035.0	36,355.0	72,710.0	-

	инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ		судалгааны институт					
8	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн ТЭЗҮ, ХЕТ	НЗД-ын 2022.06.06 А/779	Хот төлөвлөлт судалгааны институт	200,000.0	170,000.0	10,000.0	20,000.0	-
9	"Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах	НЗД-ын 2023.11.17 А/1309	ББСМО ХХК	3,553,800.0	-	-	1,954,590.0	1,599,210.0
10	"УБХотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ	НЗД-ын 2023.11.17 А/1307	Дэхан консалтинг ХХК	5,166,250.0	-	-	3,099,750.0	2,066,500.0
11	Зайсан орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гэрээ	НЗД-ын 2023.12.26 А/1517	Гобитравэл ХХК	530,000.0	-	-	159,000.0	371,000.0
12	"Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох"	НЗД-ын 2024.03.05 А/234	Геосан ХХК	5,599,744.6	-	-	1,679,923.4	3,919,821.2
13	Ашиглалтын шаардлага хангахгүй 5 дугаар байрыг дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил / СБД 6-р хороо/	НЗД-ын 2024.09.25 А/1123	Өү энд би эн ХХК	1,322,600.0	-	66,131.5	1,256,468.5	-
14	"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт боловсруулах ажлын гэрээ	НЗД-ын 2024.10.07 А/1189	Хот төлөвлөлт судалгааны институт	1,646,400.0	-	-	658,560.0	987,840.0
	Нийт дүн		-	19,439,596.1	1,342,996.2	147,353.5	8,935,790.9	9,013,455.5

Тус байгууллагад шүүхийн маргаантай дараах асуудлууд байна. Үүнээс тайлант онд 2,845,028.1 мянган төгрөгийн маргааныг шийдвэрлэсэн байна. Үүнд:

Иргэн М.Сүнжидмаа:Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны 128/ШШ2024/0251 дугаартай шийдвэрээр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 208/2019 дугаар Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг хууль бус байсан болохыг тогтоож, уг хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохиролд нэхэмжлэгч М.Сүнжидмаад 68.938.0 мянган төгрөгийг хариуцагч нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газраас гаргуулж, шинжээчийн зардал 2,624.0 мянган төгрөгийг тус газраас гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

"Өү Энд Би Эн" ХХК: "Өү Энд Би Эн" ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт холбогдох 1,322,629.4 мянган төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэгдсэн.

НЗД-ын 2019 оны А/397 дугаар, НЗД-ын 2020 оны А/163 дугаар захирамжуудаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн Сүхбаатар дүүргийн 06 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 5 дугаар байрыг буулгаж, орон сууцны барилга барьж, сууц өмчлөгчдийг шинэ орон сууцаар хангах төслийг хэрэгжүүлэхэд "Өү Энд Би Эн" ХХК шалгарсныг батламжилж, тус компанид газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигчидтэй гэрээ байгуулах эрх олгосон байна.

"Өү Энд Би Эн" ХХК нь гадна дэд бүтцийг өргөтгөх ажлын хүрээнд гадна дулаан хангамж, гадна ариутгах татуурга, гадна холбоо, гадна цахилгаан хангамж, дэд өртөөний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, улмаар гадна шугам сүлжээ, цахилгааны дэд өртөөний ажлыг өөрийн 1,322,629.5 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэн хийсэн ажлын хөлсийг нэхэмжилсэн байна. НИТХ-ын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн "2024 оны нийслэлийн төсөвт өөрчлөлт оруулах тухай" 25 дугаар тогтоолоор уг ажлын зардал нийслэлийн төсөвт суулгаж батлагдсан байна.

НЗД-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/1123 дугаартай захирамжийн дагуу “Өү Энд Би Эн” ХХК-ийн гадна дэд бүтцийг өргөтгөх ажлын хүрээнд (гадна дулаан хангамж, гадна ариутгах татуурга, гадна холбоо, гадна цахилгаан хангамж, дэд өртөө)-ний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, улмаар гадна шугам сүлжээ, цахилгааны дэд өртөөний ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн нийт 1,322,629.5 мянган төгрөгийг Нийслэлийн Засаг дарга болон, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (хуучин нэрээр)-аас гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

Монтед констракшн ХХК: Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газраас явуулсан сонгон шалгаруулалтад оролцож 2019 оны А/515 захирамжаар ЧД-ийн 2 дугаар хорооны үйлдвэр хоршооллын 12 дугаар байрыг буулгаж, дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэх эрх авсан боловч төсөв батлагдаагүй. Гэрээний дагуу 2023 оны 6 сард ашиглалтад оруулсан байна.

Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 182/ШШ2023/03122 дугаар шийдвэрээр “Монтед Констракшн” ХХК ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууны ...байрыг буулгаж, дахин барилгажуулах төслийн ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн нийт 1,522,398.6 мянган төгрөгийг Нийслэлийн Засаг дарга болон, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (хуучин нэрээр)-аас гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн тул НЗД-ын 2023 оны А/1380 дугаар захирамжаар эрх шилжүүлэн хөрөнгө шийдвэрлэж, НХБХСГ-ын хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан олгож, үндсэн хөрөнгө дансанд орлого авсан байна.

Зорилт 3. Худалдан авах ажиллагааны талаар

Тайлант 2023 он, 2024 онд нийт 1,225,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулан, 1,215,425.0 мянган төгрөгийн 4 гэрээг байгуулан ажилласан боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй, гүйцэтгэлийг огт тайлагнаагүй зөрчил байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн нь Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар тайлант онуудад нийт 1,225,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 1,215,425.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, үр дүнг цахим худалдан авах ажиллагааны <https://www.tender.gov.mn/mn> системд нийтэлсэн байна. Үүнд:

НИТХ-ын даргын Эрх шилжүүлэх тухай 2023 оны А/11, 2024 оны А/28 дугаар НИТХ захирамж, НЗД-ын 2024 оны Эрх шилжүүлэх тухай А/279 дүгээр захирамжуудын хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын даргын /хуучин нэрээр Хот байгуулалт хөгжлийн газар/ 2023 оны А/11 дүгээр тушаалаар Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор Орон сууц болон олон нийтийн зориулалттай барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах;

2024 оны А/12 дугаар тушаалаар Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор Орон сууц болон олон нийтийн зориулалттай барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах;

2024 оны А/19 дүгээр тушаалаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 онд Хот байгуулалт, хөгжлийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах ажлын

гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, мөн байгууллагынхаа урсгал зардлаас Хот байгуулалт, хотын стандартын даргын 2024 оны А/65 дугаар тушаалаар Хот байгуулалтын цахим систем eBarilga хөгжүүлэлт хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог тус тус байгуулсан байна.

Хүснэгт 15

Тендер сонгон шалгаруулалтын мэдээлэл

(мянган төгрөгөөр)

№	Төсөл арга хэмжээний нэр, тендерийн дугаар	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэгч	Гэрээ эхлэх, дуусах хугацаа
1	Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор Орон сууц болон олон нийтийн зориулалттай барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажил /2023 он/ НХБХГ/202303002	150,000.0	149,800.0	Эгэ ХХК	2023.07.26-2023.11.30
2	Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор Орон сууц болон олон нийтийн зориулалттай барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажил /2024 он/ НХБХГ/20240103001	150,000.0	149,800.0	Интеллект тауэр ХХК	2024.08.07-2024.10.30
3	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 онд Хот байгуулалт, хөгжлийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах ажил НХААГ/20240102284	725,000.0	719,325.0	Ногун ХХК	2024.05.24-2024.07.05
4	2024 онд Хот байгуулалтын цахим систем eBarilga хөгжүүлэлт хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний ажил НХБХГ/20240103002	200,000.0	196,500.0	Смарт ата ХХК	2024.11.20-2024.12.16
Нийт		1,225,000.0	1,215,425.0		

Санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа

Тус газар нь ерөнхий нягтлан бодогч 1, тооцооны нягтлан бодогч 1, эд хариуцагч 1, нийт 3 ажилтны бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Тайлант онуудад санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох санхүүгийн Acolous, ашиглаж бүртгэлийг хөтөлж, мэдээ тайланг холбогдох байгууллагад хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан байна. Албан хаагчдын цалин хөлсийг холбогдох хууль, заавар журамд нийцүүлэн тооцож, цаг хугацаанд нь олгожээ.

Тус газар нь өнөөдрийг хүртэл НБББББ-ийг батлуулаагүй, өөрчлөлт хийгдээгүй байна. Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасны дагуу бодлогын баримт бичгийг өөрийн бүртгэл, үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах хэрэгтэй байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Хот байгуулалт, хотын стандартын газрын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант 2024 онд Хотын стандартын газраас шилжиж ирсэн 19,698.5 мянган төгрөгийн өртөгтэй, Хотын 42 стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өнөөдрийг хүртэл бүртгүүлээгүй байна. Энэ нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹.2-т "Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна".12.3-т "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилтэт стандартыг стандартчилал, техникийн

зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэж болно” гэж заасныг зөрчсөн байна.

2. Тайлант онуудад байгууллагын төсвөөс 2 жил дараалан худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдан тэнцээгүй байгаа 3 албан хаагчид 510.0 мянган төгрөгийн зардал гарган төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн байна.
3. Тайлант 2023 оны 10-р сард бараа материалын тайланг гаргаж ажиллаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5.1.4. үнэн зөв байх, 5.1.5. хэмжигдэхүйц байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
4. НИТХ-ын даргын 2024 оны А/29 дүгээр захирамжийн дагуу НХААГ/20240102281 дугаартай газар хөдлөлийн чичирхийлэл хэмжигч төхөөрөмж худалдан авах ажилд Өү Ти Солюшнс ХХК шалгарч 175,130.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан байна. Тус гэрээнд нэг бүр нь 87,656.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг, нийт 175,130.0 мянган төгрөгийн хөрсний хурдатгал хэмжигч багажны иж бүрдэл нийлүүлсэн байхад данс бүртгэлд тусгаагүй, тус хөрөнгийг эрх бүхий байгууллага, НӨХГ-ын шийдвэргүйгээр Одон орон геофизикийн хүрээлэнд шилжүүлсэн зөрчил байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1. "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө": 4.1.3. "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт" заалтыг зөрчсөн байна.
5. Ebarilga Нийслэлийн хот байгуулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажилд Газрын даргын 2024 оны А/65 тушаалаар 2024.10.15-ны өдөр үнэлгээний хороо байгуулан төсвийн урсгал зардлаас 200,000.0 мянган төгрөгөөр нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр Смарт дата ХХК шалгарч 2024.11.20-ны өдөр НХБХСГ/202401020002 дугаартай, 196,500.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, 2024.12.25-нд ажлыг 100 хувь гүйцэтгэсэн гэж дүгнэн барьцаа 10 хувь авч үлдсэн санхүүжилтийг олгосон. Гэтэл ажлын даалгаварт хийгдэх ажлууд "3-т Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ, паспортжуулалт хийх үйлчилгээ нэмэх" гэж тусгасан байтал хөгжүүлэлт хийсэн систем нь Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ, паспортжуулалт хийх үйлчилгээ нэмэх гэж үүрэг өгсөн байхад барилгын дүгнэлтийн цахим архивт баяжилт хийсэн гэх цонхийг тестлэх шатандаа байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл ашиглалтад оруулаагүй байна. Гэтэл ажлын гүйцэтгэл бүрэн дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчил байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн.
6. НЗД-ын 2022 оны А/170 дугаар захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгох зөвлөх үйлчилгээний ажлын тендер зарласан байна. Гэтэл зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг хамтад нь зохион байгуулж гүйцэтгэгч Смарт дата ХХК шалгарч дэлгэц, компьютер, таблет зэрэг 8 ш, 27,200.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Энэ нь тухайн үед мөрдөгдөж байсан ТБОНӨХБАҮХАТ хуулийн 5.1.15. "зөвлөх үйлчилгээ" гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг; МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 1.2 Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,

санхүүжүүлэх, хянах, тайлагнах, тэдгээртэй холбогдсон харилцаанд энэ журмыг баримтална гэсэн заалттай нийцэхгүй байна.

7. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ, хугацааны сунгалт, нэмэлт өөрчлөлтийн гэрчилгээг бичиг хэргийн материалд бүртгэдэг бөгөөд албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас хүчингүй болсон нэг бүрийн үнэ 4400 төгрөгийн 21 ш нийт 92.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Бичигдсэн гэрчилгээг тайлант онуудад иргэн, ААН хүлээж аваагүй 58 ш байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.3/... үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа / улирлын эцсийн сарын 25-наас/ ; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ:14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх заалтыг мөрдөөгүй байна.
8. Тайлант онуудад Барилгын чанарын дүгнэлт гаргуулсан 3 харилцагч он дамжин 5,605.2 мянга, хаяг, зургийн орлого тушаасан боловч ажлаа хүлээж аваагүй 102 иргэн ААН-ийн 12,961.4 мянга, мөн дугаарын тодорхойлолтын орлого төвлөрсөн бөгөөд хаяг, дугаарын тодорхойлолт аваагүй 301 иргэн ААН-ийн 7,554.6 мянга, хаяг, дугаарын тодорхойлолт авсан боловч орлого нь тайлант онд орлого төвлөрөөгүй он дамжсан 34 иргэн ААН-ийн 2,265.6 мянга, харилцагч нь тодорхойгүй 93 иргэн, ААН-ийн 6,720.7 мянган төгрөгийн нийт 35,107.5 мянган төгрөгийн орлогыг аккурель сууриар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө заалтыг мөрдөөгүй байна.
9. Тус газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан 61,700.0 мянган төгрөгийн өртөгтэй 03-57 УБҮ улсын дугаартай Hyundai Azera суудлын тээврийн хэрэгслийг холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүлээлгэн өгсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26."Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана" заалтыг зөрчсөн байна.
10. Тайлант 2023, 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 44.1. "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
11. Тайлант 2023 онд Квант сервис ХХК-аас 4,488.0 мянган төгрөгөөр 2 ширхэг скайнер, 2024 онд Мета дета ХХК-аас 4,699.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Эн ди ти эс ХХК-аас 13,385.2 мянган төгрөгийн бетон бат бэх тодорхойлогч алх, нийт 22,572.2 мянган төгрөгийн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй, үнийн санал авч харьцуулалт хийгээгүй шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 31.2. "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
12. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа 3 ажлын нийт 345,031.5 мянган төгрөгийн дүнтэй Зураг төсөл Консалтинг ХХК-ийн гэрээний хугацаа 2022.03.28-ний өдөр дууссан байхад магадлалын нэгдсэн дүгнэлт гарахыг хүлээж байгаа шалтгаанаар өнөөдрийг хүртэл гэрээ сунгаагүй, бүртгэлд тусгагдаагүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан байна.

№	Захирамжийн огноо	Дугаар	Гэрээний дүн	Санхүүжилтийн дүн	Үлдэгдэл санхүүжилт
1	2021.06.30-2022.02.18	A/524,A/230	115,010.5	91,410.4	23,600.1
2	2021.06.30-2022.02.18	A/524,A/230	115,010.5	91,751.0	23,002.1
3	2021.06.30-2022.02.18	A/524,A/230	115,010.5	92,008.4	23,002.1
Нийт дүн			345,031.5	275,169.8	69,604.3

Энэ нь МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.2.Төсөл, арга хэмжээг хуулиар баталсан хугацаанд бүрэн ашиглалтад оруулахад захиалагчийн техник, технологийн хяналтын чиг үүргийг гэрээний дагуу үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ДҮГНЭЛТ

Хот байгуулалт, хотын стандартын газрын удирдлага, санхүүгийн ажилтнууд нь 2023 он, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад тодруулгыг холбогдох хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж баталгаажуулан ажилласан байна.

Хот байгуулалт, хотын стандартын газар нь 2024 онд Хотын стандартын газраас шилжиж ирсэн 19,698.5 мянган төгрөгийн өртөгтэй, Хотын 42 стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж ажиллах шаардлагатай.

Өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан, НӨХГ-ын албан ёсны шийдвэр ирсний дараа холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ, хугацааны сунгалт, нэмэлт өөрчлөлтийн гэрчилгээний тооцоо, бүртгэл, Барилгын чанарын дүгнэлт, Барилгын мэдээллийн сангаас хаяг, дугаарын тодорхойлолт олгох орлого, Шугам сүлжээний дэвсгэр зураг, сэдэвчилсэн болон байр зүйн зургийн орлого, харилцагч тодорхойгүй орлого бүрдүүлэлтэд нэгжүүдийн уялдаа холбоог ханган нягт хамтарч тулгалт хийн тодорхой болгох, тооцооны нягтлан бодогч, эд хариуцагч нар нь үнэт цаасны бүртгэл хөтлөлтөд тавих хяналт, хариуцлагыг дээшлүүлж ажиллах, цаашид орлогыг аккурэль сууриар бүртгэж хэвших шаардлагатай.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа 3 ажлын нийт 345,031.5 мянган төгрөгийн дүнтэй ажлуудын гэрээний хугацаа 2022 оны 03 дугаар сарын 28-ний өдөр дууссан байхад магадлалын нэгдсэн дүгнэлт өнөөдрийг хүртэл гараагүй байгаа шалтгаанаар бүртгэлд тусгагдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан тул цаашид Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд хэрэгжүүлэх Захиалагчийн хяналтыг сайжруулж, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.

Тус байгууллагад хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар байгууллагын нийт 887,042.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 175,732.4 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоон, 711,309.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг өгч байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

ЗӨВЛӨМЖ

Тус байгууллагад хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн асуудалд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хотын 42 стандартыг *стандартчилал*, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;
2. Өөрийн байгууллагын онцлогт тохируулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулан, шинэчлэн батлуулж мөрдөх;
3. Батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах;
4. Төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн ажилд тавих Захиалагчийн хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг үр ашгийг нэмэгдүүлж ажиллах;
5. Орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, харилцагчийг тодорхой болгох;
6. Тайлант онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг гаргаж хэвших;
7. НИТХ-ийн даргын 2024 оны А/29 дүгээр захирамжийн дагуу газар хөдлөлийн чичирхийлэл хэмжигч төхөөрөмж худалдан авах НХААГ/20240102281 дугаартай, нэг бүр нь 87,656.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг, нийт 175,130.0 мянган төгрөгийн нийслэлийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүждэг Одон орон геофизикийн хүрээлэнд шилжүүлэн өгсөн зөрчлийг таслан зогсоож Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26.т "Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана" заалтыг мөрдөх; Төсвийн тухай хуулийн 4.1.38."төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ" заалтыг хэрэгжүүлж, цаашид давтан гаргахгүй байх
8. Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Дотоод аудитын албанд ирүүлэхийг мэдэгдэж байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ

ДАРГА /СХШУАБ/

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ

АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /СХШУАБ/  Д.НАНСАЛМАА

БЭЛТГЭСЭН:

АУДИТ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ ДОТООД АУДИТОР /СХШУАБ/

ДОТООД АУДИТОР /СХШУБ/

ДОТООД АУДИТОР

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,

ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

З.ОТГОНБАЯР

Д.ЛУВСАНЧИМЭД

Ц.ДУЛАМДОРЖ

Б.ОТГОНТУЯА

Г.БАЯРСАЙХАН

Б.БОЛОРМАА



ИЛЭРСЭН АСУУДЛЫН НЭГТГЭЛ

Аудитын объект: Хот байгуулалт, хотын стандартын газар

№	Асуудлын утга	Холбогдох ажлын баримтын дугаар	Асуудлын ангилал (Нөлөөтэй эсэх)	Нөлөөлөх хууль тогтоомж, дүрэм, журам	Аудитын тайланд оруулах эсэх
A	1	2	3	4	5
1	Хөрөнгө, мөнгө захиран зарцуулсан 3 тушаалыг шилэн дансанд байршуулаагүй.	-	Тийм	ШДТХ-ын 6.4.8	Тийм
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025.09.22-ны өдөр шинэчлэн баталсан боловч шилэн дансанд байршуулаагүй.	-	Тийм	ШДТХ-ын 6.1.1	Тийм

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ШИЛЭН ДАНС ХАРИУЦСАН ДОТООД АУДИТОР
Д.ДАМБАРЕНЧИН

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ЗАЛРУУЛЖ АЖИЛЛАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.БАЯРСАЙХАН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Б.БОЛОРМАА

